

2015 оны 02 дугаар сард зохион байгуулсан ажлын тайлан

Мал аж ахуй салбар: Мал аж ахуйн өвөлжилтийн цаг үеийн мэдээллийг 7 хоног бүр Аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэст, 14 хоног тутамд ХХААЯ-ны МААБХЗГ-т хүргүүлэн ажиллаж байна. Үүнд: 2015 оны 2 дугаар сарын 16-ны байдлаар Том малын зүй бусын хорогдлын мэдээ нийт 20 толгой мал хорогдсон мэдээтэй байна.

“Хишигтэн нүүдэлчин” ХХК нь мах, сүүний хосолмол ашиг шимт Монтбейльярд үүлдрийн хээлтүүлэгчийн захиалга авч байгаа бөгөөд Хонгор сумын 2 дугаар багийн Малчдын бүлэг худалдан авахаар захиалгаа хүргүүллээ.

Зохиомол хээлтүүлгийн ажил, үйлчилгээний Мандах он ХХК-ний техникч 2015 оны 2 дугаар сарын 16-ны байдлаар 35 үнээг зохиомлоор хээлтүүллээ.

“Улсын Сайн малчин”-аар Шарын гол сумын Санжинт багийн малчин Л.Цэвээн, МҮОНРадиоогийн Нийгэм, Хөдөө аж ахуйн редакци, Хүнс, хөдөө аж ахуйн яам хамтарсан “Таван эрдэнэ” нэвтрүүлгийн нэрэмжит шагнал болох “Алтан тугал”-ын эзэнээр Хонгор сумын 2 дугаар багийн малчин Т.Эрдэнэсүрэн мөн аймгийн “Сайн малчин”-аар Хонгор сумын малчин Ж.Ганхуяг тус тус шалгарлаа.

“Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгох журам”-ын дагуу Сумдын 2014 оны сүүлийн хагас жилийн арьс, ширний урамшуулалд 562 хоршооны гишүүн малчдын 1045 ширхэг адуу, 5489 ширхэг үхэр, 15789 ширхэг ямаа, 27072 ширхэг хонины шир тушаасан тайланг МХСанд хүргүүллээ.

Тус аймагт Хангай, Ерөө, Орхон, Тал нутгийн цагаан, Баяд, Сартуул, Говь-алтай, Байдраг, Дархад, Торгууд, Сүмбэр үүлдрийн хонь үржүүлдэг 415 малчин өрхийн 2013 онд 36,9 мянга, 2014 онд 51,1 мянган толгой хонины судалгааг МХСанд хүргүүллээ.

Газар тариалангийн салбар: Аймгийн хэмжээнд энэ онд 12441 га-д үр тариа, 625,8 га-д төмс, 1327 га-д хүнсний ногоо, 3000 га-д тосны ургамал тариалж, 12400 га-д чанар сайтай уринш бэлтгэхээр төлөвлөөд байна. Энэхүү ажлын хүрээнд тариалалтанд шаардагдах үр, шатахуун, ургамал хамгааллын бодисын хэрэгцээг тооцон гаргаж ХХААЯ-нд хүргүүллээ. Энэхүү тооцоогоор 976 тн үр, 543.6 тонн шатахуун шаардагдах тооцоотой байна

Улсын тэргүүний тариаланч хамт олон” Хонгор сумын Түмэн буудай ХХК, “Улсын тэргүүний тариаланч”-аар Орхон сумын ногоочин Б.Үүрцайх, Ж.Отгонбаатар нар шалгарч, аймгийн “Тэргүүний тариаланч”-аар Дархан сумын ногоочин н.Цэцэнхүү шалгарсан байна

Хүнсний үйлдвэрлэлийн салбар

Үйл ажиллагаа явуулж байгаа гурилын үйлдвэрүүдээс “Улаанбуудайн үлдэгдэл, гурил үйлдвэрлэлт, борлуулалтын үнийн судалгаа”-г тогтмол авч, ҮХААЯ-д хүргүүлж байна. 2015.01.30-ны байдлаар үлдэгдэл буудай 56,7 мян.тн, гурил 4,6 мян.тн, үйлдвэрлэлт 3,9 мян.тн, борлуулалт 2,8 мян.тн, 1 кг дээд гурил БГ055-980 төг, 1-р гурил БГ085 -770-780 төг, 2-р гурил БГ115 -400-510 төг, хивэгний үнэ 370-380 төгрөгний үнэтэй байна.

Нөөцийн мах бэлтгэн нийлүүлэхээр “Дархан меат фүүдс” ХХК, ХХААЯ-тай гэрээ байгуулсан ч махны зах зээлийн үнэ өнгөрсөн жилийнхээс бага байгаа учраас нөөцийн мах борлуулах үнийг хараахан тохироогүй байна.

Үйлдвэрлэл эрхлэгчидтэй уулзалт хийснээр үзэсгэлэнгийн “Уриалга” гаргаж, 75-аас дээш насны ахмадуудад 10 хувийн хөнгөлөлт эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Цагаан сар-2015 үзэсгэлэн худалдааг 16 дахь жилдээ төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран зохион байгууллаа. Үйлдвэрлэл эрхлэгчидтэй уулзалт хийснээр үзэсгэлэнгийн “Уриалга” гаргаж, 75-аас дээш насны ахмадуудад 10 хувийн хөнгөлөлт эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Уг үзэсгэлэн худалдаанд нийт 6 аймгийн 100 гаруй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон өрхийн үйлдвэрлэгчид 10 гаруй нэр төрлийн 130 гаруй бүтээгдэхүүнээр оролцож, 200-аад сая, төгрөгийн борлуулалт хийж, ахмадуудад 2,0 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний 10 хувийн хөнгөлөлтийг үзүүлсэн байна.

СӨБ болон ЕБС-ийн 1-5-р ангийн хүүхдийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг тооцож ХБХ-т хүргүүлжээ. Аймгийн Засаг Даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж, ХБХ-тэй хамтран 18 цэцэрлэгийн гол нэрийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний 21 хоногийн бодит хэрэглээг нэгтгэн, дундаж үзүүлэлтийг гаргаж, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, гурилын Техникийн тодорхойлолтыг боловсруулан гаргалаа.

ХЭАХН-тэй хамтран ажиллаж, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Улз Баян –Уул, Голден роуз, Наро кафе, Анжел, Тулга, Даниста-2, Эрдэнэс плаза рестораны нийт 7 байгууллагын 21 тогооч, худалдагч нарт 1-р сарын 31-нд сургалт зохион байгуулж, хууль эрхзүйн мэдлэгийг олголоо.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд хүнсний үйлдвэрийн салбарт 2014 онд хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, өнөөгийн байдал болон 2015 онд хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл хийлээ.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүнсний салбарын нэг заалтын үр дүнг нэмэлтээр гаргасан байна.

Мал эмнэлэг:

2016 онд мал амьтадыг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо, толгой түүнд шаардагдах эм бэлдмэлийн захиалгыг боловсруулав. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдэд 2015 онд халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд шаардагдах үйлчилгээний хөлсний дутагдаж байгаа санхүүжилтийг орон нутгийн төсөвт тодотголоор тусгаж өгөх талаар хүсэлт гаргаж, албан тоотоор хүргүүллээ. Орон нутагт ажил үйлчилгээ эрхэлж байгаа хувийн Мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийн үйлчилгээ үзүүлдэг айл, өрх болон малын тоо толгойн судалгааг нэгж тус бүрээр нь гарган авч, 2015 оны эм бэлдмэлийн хуваарилахдаа үүнийг үндэслэж байна. Европын холбооны санхүүжилттэй

“Малын эрүүл мэнд” төсөлд Дархан-Уул аймгийн үхэр сүрэгт бруцеллёзын шинжилгээ хийхээр төсөл бичиж томилолт, шатахууны зардлыг гаргуулахаар албан тоотоор хүргүүлэв.

2015 оны эм бэлдмэлийн захиалганд тухайн ондоо батлагдсан төсөвт багтаан өөрчлөлт оруулахаар дахин тооцоо, судалгаа хийж байна. Мал эмнэлгийн хугацаатай сарын мэдээг гарган МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газарт хүргүүлэв.

БАТЛАВ: ГАЗРЫН ДАРГА...../Ц.ЭНХЖАРГАЛ /

**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
2015 ОНЫ 03 ДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| Д/д | Хийгдэх ажил | Огноо | Хариуцах эзэн | Хүрэх үр дүн |
|-----------------------------|--|-------------------|---------------|--|
| Мал аж ахуйн хэлтэс | | | | |
| 1. | Төлийн мэдээ, том малын хорогдлын мэдээг авч нэгтгэх | 3 дугаар сарын 1 | С.Баасан | Тайланг үнэн зөв гаргасан байна. |
| 2. | Хишиг өдөр арга хэмжээ зохион байгуулах | 3 дугаар сарын 31 | МААХ | Орхон сумын МЭҮТ-тай хамтран зохион байгуулна. |
| 3. | Малчин өрхөд мэргэжлийн үнэмлэх, энгэрийн тэмдэг олгох | 3 дугаар сарын 16 | С.Баасан | Сумдаас захиалга авч нэгтгэсэн байна. |
| 4. | Малчин, мал бүхий өрхөд баталгааны тэмдэг олгох | 3 дугаар сарын 16 | С.Баасан | Сумдаас захиалга авч нэгтгэсэн байна. |
| 5. | Малын ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийн мэдээ | 3 дугаар сарын 27 | С.Баасан | Тайланг үнэн зөв гаргасан байна. |
| Мал эмнэлгийн хэлтэс | | | | |
| 6. | 2015 оны халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээний эм бэлдмэлийн хуваарийг гарган газрын | Сардаа | Х.Хавсамет | Хуваарийг батласан байна. |

| | | | | |
|---|--|--------------|--------------------|--|
| | даргаар батлуулах | | | |
| 7. | 2015 оны үр дүнгийн гэрээний төслийг боловсруулж газрын даргаар батлуулах | Сардаа | Х.Хавсамет | Үр дүнгийн гэрээ байгуулсан байна. |
| 8. | 2015 онд сумдын МЭҮТасаг, нэгжүүдэй байгуулах үр дүнгийн гэрээний төсөл боловсруулах | Сардаа | Х.Хавсамет | Үр дүнгийн гэрээний төсөл боловсруулж батлахад бэлэн болгосон байна. |
| 9. | Орон нутгийн МЭ-ийн анхан шатны нэгжүүд, МЭҮТасагтай гурвалсан гэрээ байгуулах | Сардаа | Х.Хавсамет | МЭҮНэгжүүд, МЭҮТасагтай гурвалсан гэрээ байгуулсан байна. |
| 10. | Хэлтсийн 2015 оны календарчилсан төлөвлөгөөний самбарыг шинэчлэх | Сардаа | Баасансүрэн Цолмон | Төлөвлөгөөтэй болсон байна. |
| Үйлдвэр, газар тариалангийн хэлтэс | | | | |
| 11. | Чацаргана хөтөлбөрийн хүрээнд олгогдсон суулгацны эргэн төлөлтийн мэдээг гарган ХХААЯ-нд хүргүүлэх | 3 сарын 05 | О.Нэмэхбат | Зээлийн эргэн төлөлтийн графикийг гаргаж хүргүүлсэн байна. |
| 12. | 2014 оны газар тариалангийн үйлдвэрлэлтийн мэдээг суурь судалгаанд нэгтгэн харьцуулалт хийх | 3 сарын 10 | О.Нэмэхбат | Судалгаанд нэгтгэн харьцуулалт хийсэн байна. |
| 13. | ХОМ-ийн дэлгэргүйг гарган ХЗХэлтэс хүргүүлэх | 3- сарын 01 | О.Нэмэхбат | ХОМ-ийн дэлгэргүйг гарган ХЗХэлтэст хүргүүлсэн байна. |
| 14. | 2015 оны тариалалтад хадгалагдаж буй үрийг МХГ-тай хамтран бүрэн шинжилгээнд хамруулах | 3 сарын 5-10 | О.Нэмэхбат | Бүрэн шинжилгээнд хамруулж үрийн чанарыг тодорхойлсон байна. |
| 15. | Үр дүнгийн гэрээг гарган батлуулах | 3 сарын 01 | О.Нэмэхбат | Үр дүнгийн гэрээ байгуулсан байна. |

| | | | | |
|-----|--|------------|------------|--|
| 16. | Гурилын үйлдвэрээс “Улаан буудайн үлдэгдэл, гурил үйлдвэрлэлт, борлуулалтын үний судалгаа” гаргаж ХХААЯ-д хүргэх | 2 сарын 25 | Г.Тунгалаг | Судалгааг хугацаанд гаргаж, мэдээг хүргэсэн байна. |
| 17. | Хүнсний үйлдвэрийн судалгааг чиглэл бүрээр гаргаж ХХААЯ-ны ХҮБХЗГ,ХШҮДАГ-т хүргүүлэх | 3 сарын 06 | Г.Тунгалаг | Судалгааг хугацаанд гаргаж, мэдээг хүргэсэн байна. |
| 18. | Салбарын мэдээлэл хийх, хууль сурталчлах, зохистой дадал нэвтрүүлэх сургалт зохион байгуулах | сардаа | Г.Тунгалаг | Хуул эрх зүйн мэдлэгийг олгосон байна. |
| 19. | 2015 онд хэрэгжүүлэх “Үр дүнгийн гэрээ боловсруулах | сардаа | Г.Тунгалаг | Жилийн ажлын гэрээ байгуулахад бэлэн болсон байна. |

Төлөвлөгөөг нэгтгэсэн: Бичиг хэрэг, архивын эрхлэгч Д.Баярмаа

Төлөвлөгөөг хянасан: ЗУХэлтсийн дарга Б.Бат-Эрдэнэ